



**ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ**

2019 оны 07 сарын 29 өдөр

Дугаар A/130

Ховд

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар Ховд аймгийн Жаргалант сум Багш нарын байр, Болорын 27 айлын орон сууцны гадна талбайн засвар, тохижилт ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Б.Гомбосүрэн - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга

Гишүүд: Б.Ариунбилэг - Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын дарга

Б.Батзол - Төрийн бус байгууллагын төлөөлөл

П.Эрдэнэ-Очир - Иргэний төлөөлөл

Нарийн бичгийн дарга:  
Х.Дэмид - Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн

2. Үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл авах, тендер шалгаруулалтыг хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулан явуулж үр дүнг танилцуулахыг Үнэлгээний хороо / Б.Гомбосүрэн/-нд үүрэг болгосугай.

3. Дээрх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаатай холбоотой бүх баримт бичгээр хадгаламжийн нэгж үүсгэхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга / Х.Дэмид /-д үүрэг болгосугай.

ДАРГА



Д.ЭНХБОЛД

2019 ТГ А/130 Ч  
02 00624